



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/21/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Алтай хот	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
2022 он	Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546	Цахим хаяг: Vujiinkhandj@audit.gov.mn
	Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016	Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 88

танай _____ -ны № _____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ОРГИЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор илүү, дутуу төлөлт цахим системд бүртгэлтэй, төсвийн хэмнэлтийн талаар баримтлах арга хэмжээг баримтлаагүй хөрөнгө бэлтгэсэн, малжуулалтын гэрээний хугацаа дууссан, малыг дараагийн айлд шилжүүлээгүй байгаа 157.3 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07020370

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	188,016,708.02	133,509,737.02
33	АВЛАГА	4,671,121.00	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	257,258.00	0.00
33500	Бусад авлага	4,413,863.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	871,700.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,542,163.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	183,345,587.02	133,509,737.02
35100	Түүхий эд материал	0.00	1,729,000.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	1,729,000.00
35400	Хангамжийн материал	23,646,587.02	26,190,737.02
35410	Бичиг хэргийн материал	1,467,250.00	1,560,500.00
35420	Аж ахуйн материал	6,626,118.00	6,710,518.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	1,155,000.00
35450	Барилгын засварын материал	1,473,600.00	1,473,600.00
35470	Бусад хангамжийн материал	14,079,619.02	15,291,119.02
35600	Мал амьтад	159,699,000.00	105,590,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,968,917,268.69	2,255,200,028.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,968,917,268.69	2,255,200,028.74
39200	Биет хөрөнгө	1,960,874,588.69	2,247,157,348.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,117,835,997.44	2,419,414,130.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-456,151,523.12	-525,199,354.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,252,572.00	215,252,572.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-120,946,966.93	-133,124,904.91
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	120,361,774.78	129,670,574.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,025,333.55	-90,471,090.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,779,177.00	27,004,891.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,309,635.77	-16,251,099.42
39209	Зам, гүүрийн байгууламж	148,297,762.00	148,297,762.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-19,351,518.69	-25,716,806.85
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	122,458,000.00	177,800,191.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-86,325,716.47	-89,519,516.47
39300	Биет бус хөрөнгө	8,042,680.00	8,042,680.00
39301	Програм хангамж	10,762,680.00	10,762,680.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,720,000.00	-2,720,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,156,933,976.71	2,388,709,765.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	261,908.00	2,180,955.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	261,908.00	2,180,955.00
41300	Өглөг	261,908.00	2,180,955.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	255,955.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,650.00	0.00
41360	Бусад өглөг	257,258.00	1,925,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	1,925,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	257,258.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,156,672,068.71	2,386,528,810.76
51	Засгийн газрын хувь оролцоо	2,156,672,068.71	2,386,528,810.76
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	196,494,040.37	196,494,040.37
51200	Хуримтлагдсан үр дүн	1,755,565,261.91	1,985,422,003.96
51210	Өмнөх үеийн үр дүн	1,614,193,279.07	1,752,023,098.90
51220	Тайлант үеийн үр дүн	141,371,982.84	233,398,905.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	204,612,766.43	204,612,766.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,156,933,976.71	2,388,709,765.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	617,583,131.80	738,881,112.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	255,814,027.80	359,504,324.00
120	Нийтлэг татварын бус орлого	255,814,027.80	359,504,324.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	255,814,027.80	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,141,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	254,673,027.80	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	357,570,324.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	1,934,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	361,769,104.00	379,376,788.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	32,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	32,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,212,204.00	20,588,188.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,150,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,742,204.00	15,902,588.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	320,000.00	4,685,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	335,556,900.00	326,788,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,556,900.00	326,788,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	476,211,148.96	505,482,206.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,211,148.96	505,482,206.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,908,231.23	500,193,000.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,492,661.85	210,597,051.89
210101	Үндсэн цалин	190,826,339.35	194,515,849.89
210105	Гэрээт ажлын хөлс	16,666,322.50	16,081,202.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,416,383.53	27,958,286.02
210201	Тэтгэврийн даатгал	18,136,678.64	19,447,064.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,133,726.53	2,119,955.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,666,661.27	1,685,883.94
210204	Ажилгүйдлийн даатгал	401,198.23	416,598.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,078,118.86	4,288,785.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,747,916.89	32,410,087.68
210301	Гэрэл, цахилгаан	3,921,829.89	3,035,960.68
210302	Түлш, халаалт	35,111,087.00	28,388,877.00
210303	Цэвэр, бохир ус	715,000.00	985,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,689,240.00	94,437,845.00
210401	Бичиг хэрэг	2,688,150.00	6,542,250.00
210402	Тээвэр, шатахуун	27,408,950.00	28,619,575.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,450,240.00	1,556,020.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,172,900.00	3,431,000.00
210408	Бараа материал ахталсны зардал	2,880,000.00	54,109,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,621,980.00	1,950,500.00
210604	Урсгал засвар	7,621,980.00	1,950,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,102,000.00	3,579,800.00
210702	Дотоод албан томилолт	2,102,000.00	3,579,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,705,204.00	6,039,866.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,292,204.00	5,124,563.00

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	444,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	555,000.00	368,000.00
210807	Газрын төлбөр	0.00	4,083.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,132,844.96	123,219,563.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,538,500.00	7,784,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	222,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	121,414,344.96	115,213,063.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,302,917.73	5,289,206.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,261,876.00	2,999,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,261,876.00	2,999,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,041,041.73	2,289,406.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,935,971.73	2,289,406.40
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	105,070.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	141,371,982.84	233,398,905.06
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	141,371,982.84	233,398,905.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	1,614,193,279.07	2,015,300,085.87
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	1,614,193,279.07	2,015,300,085.87
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	141,371,982.84	141,371,982.84
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	1,755,565,261.91	2,156,672,068.71
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	1,755,565,261.91	2,156,672,068.71
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-3,542,163.00	-3,542,163.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	1,752,023,098.91	2,153,129,905.71
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	233,398,905.06	233,398,905.06
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	1,985,422,003.96	2,386,528,810.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	362,910,104.00	379,634,046.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,141,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,141,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,141,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,141,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	361,769,104.00	379,634,046.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	32,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	32,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,212,204.00	20,845,446.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,150,000.00	257,258.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,742,204.00	15,902,588.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	320,000.00	4,685,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	335,556,900.00	326,788,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,556,900.00	326,788,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	357,913,104.00	337,633,546.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,913,104.00	337,633,546.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,352,928.27	332,344,339.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,492,661.85	210,341,096.89
210101	Үндсэн цалин	190,826,339.35	194,259,894.89
210105	Гэрээт ажлын хөлс	16,666,322.50	16,081,202.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,416,383.53	27,958,286.03
210201	Тэтгэврийн даатгал	18,136,678.64	19,447,064.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,133,726.53	2,119,955.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,666,661.27	1,685,883.94
210204	Ажилгүйдлийн даатгал	401,198.23	416,598.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,078,118.86	4,288,785.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,757,916.89	32,410,087.68
210301	Гэрэл, цахилгаан	3,921,829.89	3,035,960.68
210302	Түлш, халаалт	35,111,087.00	28,388,877.00
210303	Цэвэр, бохир ус	725,000.00	985,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,044,940.00	38,065,745.00
210401	Бичиг хэрэг	3,339,300.00	2,642,500.00
210402	Тээвэр, шатахуун	28,276,000.00	31,473,525.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,450,240.00	1,556,020.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,890,400.00	2,213,700.00
2105	Нормативт зардал	450,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,794,322.00	3,563,258.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	206,500.00
210604	Урсгал засвар	8,794,322.00	3,356,758.00
2107	Томилолт, зочны зардал	2,102,000.00	3,579,800.00
210702	Дотоод албан томилолт	2,102,000.00	3,579,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,055,204.00	6,039,866.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,642,204.00	5,124,563.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	444,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	99,000.00

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	555,000.00	368,000.00
210807	Газрын төлбөр	0.00	4,083.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,239,500.00	10,386,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,718,500.00	9,886,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,521,000.00	499,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,560,175.73	5,289,206.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,261,876.00	2,999,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,261,876.00	2,999,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,298,299.73	2,289,406.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,935,971.73	2,289,406.40
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	362,328.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,997,000.00	42,000,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,997,000.00	42,000,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,997,000.00	42,000,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,997,000.00	42,000,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,997,000.00	42,000,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,997,000.00	-42,000,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	358,788,600.00	356,499,193.60	2,289,406.40	99%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,788,600.00	356,499,193.60	2,289,406.40	99%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,788,600.00	353,499,393.60	2,289,206.40	99%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,684,600.00	210,341,096.89	1,343,503.11	99%
210101	Үндсэн цалин	194,590,000.00	194,259,894.89	330,105.11	100%
210105	Гэрээт ажлын хөлс	17,094,600.00	16,081,202.00	1,013,398.00	94%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,166,700.00	27,958,286.03	208,413.97	99%
210201	Тэтгэврийн даатгал	19,679,300.00	19,447,064.06	232,235.94	99%
210202	Тэтгэмжийн даатгал	2,121,800.00	2,119,955.01	1,844.99	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,697,500.00	1,685,883.94	11,616.06	99%
210204	Ажилгүйдлийн даатгал	424,400.00	416,598.00	7,802.00	98%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,243,700.00	4,288,785.02	-45,085.02	101%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,529,300.00	32,410,087.68	119,212.32	100%
210301	Гэрэл, цахилгаан	3,140,000.00	3,035,960.68	104,039.32	97%
210302	Түлш, халаалт	28,389,300.00	28,388,877.00	423.00	100%
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	985,250.00	14,750.00	99%
2104	Хангамж, бараа материалын зардал	29,798,000.00	29,711,720.00	86,280.00	100%
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,498,900.00	1,100.00	100%
210402	Тээвэр, шатахуун	24,000,000.00	23,985,100.00	14,900.00	100%

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,618,000.00	1,550,020.00	67,980.00	96%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00	0.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,497,700.00	2,300.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,020,000.00	40,996,900.00	23,100.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,020,000.00	37,997,400.00	22,600.00	100%
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,999,500.00	500.00	100%
2107	Томилолт, зочны зардал	3,600,000.00	3,579,800.00	20,200.00	99%
210702	Дотоод албан томилолт	3,600,000.00	3,579,800.00	20,200.00	99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,390,000.00	915,303.00	474,697.00	66%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	444,220.00	155,780.00	74%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	99,000.00	1,000.00	99%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	660,000.00	368,000.00	292,000.00	56%
210807	Газрын төлбөр	30,000.00	4,083.00	25,917.00	14%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,600,000.00	7,586,200.00	13,800.00	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,100,000.00	7,086,500.00	13,500.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	499,700.00	300.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	2,999,800.00	200.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	2,999,800.00	200.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,999,800.00	200.00	100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	358,788,600.00	358,788,600.00	0.00	100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	358,788,600.00	358,788,600.00	0.00	100%
320001	Орон нутгийн төсвөөс	358,788,600.00	358,788,600.00	0.00	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	19.00	0.00	100%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	0.00	100%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00	0.00	100%
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00	0.00	100%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00	0.00	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	20,845,446.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	20,845,446.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	20,845,446.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	8,354,025.00
210401	Бичиг хэрэг		143,600.00
210402	Тээвэр, шатахуун		7,488,425.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		6,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		716,000.00

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,566,858.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,209,600.00
210604	Урсгал засвар		357,258.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,124,563.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,124,563.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	20,845,446.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	20,845,446.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	257,258.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,902,588.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,685,600.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газар нь “Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албаны стандартыг хангах, төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлан хэрэгжүүлэх, засаг даргыг цаг үеэ олсон мэргэжлийн зөвлөмжөөр хангах зорилготой” байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 476.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 505.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.0 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90 хувиар буюу 231.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 133.5 сая төгрөг болж 82.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 48.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 1.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авч, үйл ажиллагаандаа 46.5 сая төгрөгийн материалыг зарцуулж, 54.1 сая төгрөгийн мал акталж данснаас хассантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,138.2 сая төгрөг болж 388.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 359.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 13.0 сая төгрөгийн хөрөнгийн акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,386.5 сая төгрөг болж 229.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 19.6 хувиар буюу 121.3 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон 3.5 сая төгрөгийн хувь хүнээс авах авлагыг хаасан бичилт хийгдсэн ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,985.4 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 535.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 176.7 сая төгрөгөөр бууруулж, 358.8 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь цалингийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, томилолт, зочны зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 358.8 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 358.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 356.5 сая төгрөгийг зарцуулж 2.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 356.5 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.1 сая төгрөгөөр, хангамж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 0.5 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 20.8 сая төгрөгийн орлого хүлээн авч, 8.4 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 4.6 сая төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 5.1 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг зардалд, 2.8 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар үзэхэд 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцсэн байна.

3.9.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 0.7 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийснийг аудитын явцад залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 81.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 2.2 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар малжуулах гэрээг сунгасан эсэх, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 173.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 16.4 сая төгрөгийн алдааг залруулж, 157.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 0.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 10.0 сая төгрөгийн автомашиныг шилжүүлснийг данснаас хасаагүй, 0.3 сая төгрөгийн өглөг илүү тайлагнасан, 4.7 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг дансны ангилал зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Мөн 0.7 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоосон алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

4.3 Албан шаардлага

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 32.0 сая төгрөгийн автомашин, 0.4 сая төгрөгийн тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5-д "автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 2.2 сая төгрөгийн илүү, 13.0 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Малжуулалтын гэрээг тулган баталгаажуулахад бараа материалын дансанд бүртгэлтэй 12.0 сая төгрөгийн 15 үхрийн гэрээ дууссан, дараагийн айлд шилжүүлээгүй, 93.6 сая төгрөгийн 1,887 малын гэрээнд тоо толгойг шинэчилж тусгаагүй байгаа нь малчидтай байгуулласан гэрээ, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж

заасныг зөрчсөн, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 3 компаниас 4.0 сая төгрөгийн хандив авсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөх алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газар	7	173.7	2	16.4	0	0	5	157.3	0	0